



**МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ**

2011 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 52

Улаанбаатар хот

Г Гадаадад сургалтын төрийн сангийн  
зээлээр суралцуулах тухай

Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ыг үндэслэн Монгол Улсын их сургуулийн багш нарын чадавхийг дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар Монгол Улсын их сургуулийн багш Батсүхийн Баяржаргалыг Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Оснабрюкийн их сургуулийн докторантурт Математикийн чиглэлээр 3 жилийн, Монгол Улсын их сургуулийн багш Гэндэнсүрэнгийн Багаболдыг Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Кемнитцийн их сургуулийн докторантурт Программ хангамжийн инженерийн чиглэлээр 3 жилийн, Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулийн багш Дагвадоржийн Нэргүйг Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Вюрцбургийн их сургуулийн докторантурт Трансфузиологийн чиглэлээр 3 жилийн, Отгонтэнгэр их сургуулийн багш Эрдэнэбатын Ганбатыг АНУ-ын Калифорний олон улсын их сургуулийн магистрантурт Олон улсын бизнес, худалдааны чиглэлээр 2 жилийн хугацаатайгаар суралцуулсугай.

2. Суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД



Ё.ОТГОНБАЯР